

“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2009 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ АЙМАГ, ОРОН НУТАГТ ХАМААРАЛТАЙ ЗОРИЛТ,  
АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТОВЧОО

2010.03.29

Баянхонгор

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт			
Хяналтад авсан нийт тоо		77	
Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо			
Үүнээс	Биелсэн /100%/		47
	Хэрэгжих шатандаа		30
	Үүний дотор	90%	18
		70%	7
		50%	2
		30%	3
		10%	х
	Тасарсан		х
Хэрэгжилтийн дундаж хувь:		90.9%	

БИЕЛЭЛТИЙГ НЭГТГЭН ГАРГАСАН:

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭНИЙ  
ТАСГИЙН ДАРГА

М.ӨНӨРЖАРГАЛ

ТАНИЛЦАЖ ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ч.ГОМБОДОРЖ

**“МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2009 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ АЙМАГ, ОРОН НУТАГТ ХАМААРАЛТАЙ ЗОРИЛТ,  
АРГА ХЭМЖЭЭНҮҮДИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

**2010.03.29.**

**Баянхонгор**

<b>№</b>	<b>Зорилт, арга хэмжээ</b>	<b>Хэмжих нэгж, шалгуур үзүүлэлт</b>	<b>Хэлтэс, агентлаг, ажилтны нэр</b>
<b>НЭГ. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО</b>			
1	1.2.Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй зарцуулахад чиглэсэн бодлого хэрэгжүүлэх	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Төсвийг үр ашигтай, хэмнэлттэйгээр төлөвлөн төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдлийг аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх 2010, 2011, 2012 оны төсвийн төлөвлөлтийг боловсруулан Сангийн яаманд шалгуулан тусгаж цаашдаа нэмэх өөрчлөлтийг жил бүрийн үндсэн чиглэлд оруулан батлуулан ажиллаж байна.  /Хэрэгжилт-100%/
2	1.11.Хүн ам, орон сууцны 2010 оны ээлжит тооллого явуулах бэлтгэлийг хангах хүрээнд хүн амын мэргэжил, албан тушаалын ангилал, боловсролын түвшний ангилал, код, ойлголтын тодорхойлолт зэргийг шинэчлэн боловсруулах	<i>Баримт бичиг бэлэн болсон байх</i>	Хүн ам орон сууцны улсын тооллогын бэлтгэлийг хангах, зохион байгуулан явуулах аймгийн комисс аймгийн Засаг даргаар ахлуулан байгуулагдаж ажиллаж байгаа бөгөөд Сумдын тооллогын комисс, аймгийн түр товчооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг даргын 242 тоот захирамжаар батлан хэрэгжүүлж энэ дагуу нийт сумдад комисс, түр товчоод байгуулагдаад байна. Хүн ам өрхийн бүртгэлийн дэвтрийн хөтлөлтийг сайжруулах чиг үүргийг өгч улирал тутам мэдээллийн санг авч шалгах ажлыг зохион байгуулж байна.  /Хэрэгжилт 100%/
<b>ХОЁР. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>			
3	3.3.Үндэсний стандартуудыг олон улсын стандартын түвшинд ойртуулах, хүргэх замаар хувийн хэвшлийн өрсөлдөх чадварыг	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Аймгийн төвийн 20 аж ахуй нэгжийн 45 нэрийн бүтээгдэхүүн, 85 үйлчилгээний цэг салбарт стандартыг хангуулж “Тохирлын гэрчилгээ” олголоо. Шинээр үйл ажиллагаа эрхэлж байгаа “Их халбагант” ХХК-ийн ингэний ундаа савлах цех, “Баруун шанд” ХХК-ийн сүү тараг

	дээшлүүлэх		боловсруулах үйлдвэр дээр тохирлын үнэлгээ хийсэн. /Хэрэгжилт-100%/
4	3.8.Үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжсэн урт хугацааны бага хүүтэй зээлийн тааламжтай нөхцлийг бий болгоход дэмжлэг үзүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2009 онд Баянлиг суманд 5.6 сая төгрөгийн өртөгтэй сүү боловсруулан савлах цех, Баянхонгор аймгийн төвд 70,0 сая төгрөгийн өртөгтэй сүү боловсруулан савлах дунд үйлдвэр ашиглалтанд оруулж, “Үйлдвэржилтийн жил” болгон зарласантай холбогдуулж жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төслийн хөнгөлөлттэй зээлийг 50 аж ахуй нэгж, иргэнд нийт 743 сая төгрөгийн зээл олгосон /Хэрэгжилт-100%/
5	3.11.Аймаг, нийслэлд “Жижиг, дунд үйлдвэр хөгжүүлэх сан”-г байгуулж, жижиг, дунд бизнесийг дэмжих	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Аймагт жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх шинэчилсэн дэд хөтлбөрийг ИТХ-аар батлуулан үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлийг нарийвлан тогтоож мөрдөн ажиллаж байна. /Хэрэгжилт-100%/
6	3.12.1.Нарийн, нарийвтар ноост хонь өсгөх ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Богийн хээлтүүлэгчийн санг 200-аас доошгүй хээлтүүлэгчээр бүрдүүлэх зорилт тавин ажилласны үр дүнд цөм сүрэгтэн өрх 458 болж, малын тоо 93341 хүрэв. /Хэрэгжилт-90%/
7	4.3.Сумын төв болон малчин өрхийг сэргээгдэх эрчим хүчээр хангах	Хамрагдах сум,	Сэргээгдэх эрчим хүчээр хангагдсан Баян-Өндөр, Шинэжинст, Баянцагаан 3 сум байна. Одоогийн байдлаар дээрх сумдын нар салхины цахилгаан үүсгүүрүүд бүрэн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй байгаа учир гүйцэтгэгч компани болон сэргээгдэх эрчим хүчний төв зэрэг холбогдох байгууллагуудад саналаа уламжлаад байна. /Хэрэгжилт-70%/
8	4.3.1.Багийн төвүүдийн цахилгаан хангамжийн судалгаа хийх	Малчин өрхийн тоо	Аймгийн хэмжээнд нарны цахилгаан үүсгүүртэй малчин өрх 7476 байна. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх “Хөдөөгийн цахилгаан хангамжид сэргээгдэх эрчим хүчнийг ашиглах төсөл”ийн хүрээнд 2010 онд нийтдээ 2048 малчин өрхийг цахилгааны эх үүсвэрээр хангах захиалга хүргүүлэн ажиллаж байна. /Хэрэгжилт-90%/
	5.1.Хүнсний бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах, иргэдийг үнийн өсөлтөөс хамгаалах	Үйл ажиллагааны	2009 онд малчдын гар дээр байсан 574,9 тн махыг зах зээлд зуучлан борлуулах арга хэмжэ авлаа.

9	чиглэлээр гадаад түншүүдтэй нягт хамтран ажиллаж, энэ чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх	<i>хэрэгжилтээр</i>	/Хэрэгжилт-70%/
10	5.1.2.Бараа, түүхий эдийн нөөцөд тулгуурласан удаан хугацаанд хадгалагдах сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэх аж ахуйн нэгжид зээлийн дэмжлэг үзүүлэх	<i>Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү, сүүн бүтээгдэхүүн /Сая литр/</i>	Баянлиг суманд 5.6 сая төгрөгийн өртөгтэй сүү боловсруулан савлах цех, Баянхонгор аймгийн төвд 70 сая төгрөгийн өртөгтэй сүү боловсруулан савлах үйлдвэр ашиглалтад ороход нь дэмжлэг үзүүлж Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих зээлд хамрууллаа. /Хэрэгжилт-100%/
11	5.2.Хүнс, хөдөө аж ахуйн түүхий эд, бүтээгдэхүүнийг борлуулах биржийн сүлжээ бий болгох	<i>Бирж байгуулах</i>	Судлагдаж байгаа /Хэрэгжилт-30%/
12	5.3.Өрхийн аж ахуйгаас бэлтгэсэн илүүдэл төмс, хүнсний ногоо, мах, сүү, цагаан идээ борлуулах, татвар, түрээсийн төлбөргүй хүнсний зах, салбар, цэгүүдийг аймаг, сумын төв, нийслэлийн дүүрэг, хороодод байгуулж, ажиллуулах	<i>Хүнсний зах, цэгүүд ажиллаж эхлэх</i>	Аймгийн хэмжээнд хүнсний томоохон 2 зах, сум бүрт улирлын чанартай хүнсний цэгүүд ажиллаж өрхийн аж ахуйгаас бэлтгэгдсэн бүтээгдэхүүнүүдийг ард иргэдэд худалдан борлуулж байна. Аймгийн төвд баригдаж байгаа “Баруун бүсийн худалдааны төв”-ийн барилгын ажил 70%-тай баригдаж байна. /Хэрэгжилт-90%/
13	5.4.Нийслэл болон орон нутгийн томоохон хотуудад экологийн цэвэр сүү, цагаан идээ, мал болон гахай, тахианы мах, махан бүтээгдэхүүн, өндөгний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, “Сүү” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Мах боловсруулах үйлдвэрийн төсөл хийх судалгааны ажил хийгдэж байгаа. Сүү хөтөлбөрийн хүрээнд аймгийн төвийн ойролцоо “Алатау” үүлдрийн 10 үнээтэй сүүний ферм байгуулагдан аймгийн төвийн сүүний үйлдвэрт сүүгээ нийлүүлж байна. /Засгийн газраас сүү хөтөлбөр боловсруулагдаагүй байгаа./ /Хэрэгжилт-90%/
14	5.8.Малын чанарыг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөрүүдийг	<i>Цөм сүргийн тоо</i>	Цөм сүргийн үржлийн төв аттестачлалд орж , одоо 1600 гаруй малтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

	боловсруулж, шилмэл үүлдрийн мал, омгийг бүртгэлжүүлж, цөм сүргийн үржлийн төвийн үйл ажиллагааг дэмжих	<i>/Мянган толгой/</i>		<i>/Хэрэгжилт-90%/</i>
15	5.9.Мал аж ахуйн салбарт хөдөлмөрөө хорших, хөрөнгө хүчээ нэгтгэх, хоршоо, нөхөрлөл, бүлэг болон зохион байгуулагдаж ажиллахыг зээл, татварын бодлогоор дэмжих	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	2009 оныг “Үйлдвэржилтийн жил” болгон зарласантай холбогдуулж аймгийн хэмжээнд мал аж ахуйн болон газар тариалангийн 220 гаруй бүлэг хоршоо, нөхөрлөл байгуулагдаж, олон улсын төсөл хөтөлбөр, жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төслийн хөнгөлөлттэй зээлд 50 аж ахуй нэгж, иргэнд нийт 743 сая төгрөгийн зээл олгосон.	<i>/Хэрэгжилт-100%/</i>
16	5.10.Малын угаалга, туулгалт, вакцинжуулалт зэрэг урьдчилан сэргийлэх арга хэмжээг төрөөс хариуцан санхүүжүүлэх ажлыг эхлүүлэх	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Мал эмнэлгийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд 2009 оны байдлаар 210,0 сая төгрөгийн санхүүжилт авч 2,017,175 сая мал хамрагдахаас 2,092,056 мал хамрагдаж 103,7 % --тай хэрэгжүүлсэн байна.	<i>/Хэрэгжилт-100%/</i>
17	5.12.”Атрын гурав дахь аян”-ы хэрэгжилтийг эрчимжүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, дотоодын үйлдвэрлэлийн улаан буудай, төмс, хүнсний ногооны хангамжийг дээшлүүлэх	<i>Дотоодын тариалан төмс, хүнсний ногооны хангалтын хувь</i>	“Атрын гурав дахь аян”-ы хүрээнд сум бүрт 4-5 төрлийн агрегат бүхий 1-2 жижиг оврын трактор, 120 м <sup>2</sup> талбай бүхий хальсан хүлэмжтэй, 20 сум зоорьтой болсон.	<i>/Хэрэгжилт-90%/</i>
18	5.14.Иргэдийн оролцоотойгоор хөв, цөөрөм байгуулах, гар худаг гаргах үйл ажиллагааг дэмжиж, бэлчээрийн худаг, уст цэгт шинэчлэл хийх ажлыг эрчимжүүлэх	<i>Шинээр гаргах худгийн тоо</i>	2009 онд улсын төсвийн хөрөнгөөр 25 худаг шинээр гаргаж, иргэдийн оролцоотойгоор 51 гар худаг гаргалаа.	<i>/Хэрэгжилт-100%/</i>
19	5.16.Байгалийн гамшгийн улмаас малгүй болсон иргэдийг малжуулах төсөлд хамруулах	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Дэлхийн Зөн” ОУБайгууллагаас Өлзийт, Эрдэнэцогт, сумдад хурга төсөл хэрэгжүүлж байна. /тоо/	<i>/Хэрэгжилт-50%/</i>
	5.19.Бэлчээр, тариалангийн	<i>Энгийн болон</i>	Огтотно устгах арга хэмжээнд 7 сум 35000 га талбай хамрагдаж үлийн	

20	талбайн хортон мэрэгч, шавьжтай тэмцэх ажлыг зохион байгуулах	<i>биологи, химийн аргаар тэмцэх талбай /Мян/га</i>	цагаан оготной тэмцэх ажил эхэлсэн. Огтоно устгалын арга хэмжээний үр дүн 80,6%-тай гэсэн үнэлэлт авлаа  /Хэрэгжилт-90%/
21	5.20.Мал аж ахуйг эрчимжүүлэх ажлын хүрээнд малын тэжээлийн үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх арга хэмжээ авах	<i>Хураан авах тэжээл /Мянган тн/</i>	2009 онд тэжээлийн ургамал 76,5 га-д тариалж, 187 тн ургац хураан авч хадлангийн талбай сайжруулах төсөлд Өлзийт, Бөмбөгөр, Шинэжинст сумд хамрагдаж, тус бүр 8,0 сая нийт 24,0 сая төгрөгийн санхүүжилтээр 30 га талбайг сайжрууллаа.  /Хэрэгжилт-90%/
22	5.21.Малын эм бэлдмэлийг дотоодын үйлдвэрлэлээр хангах арга хэмжээг дэмжиж, мал амьтны гоц халдварт болон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах	<i>Малын халдварт өвчний бууралт /Хувь/</i>	Урьдчилан сэргийлэх арга хэмжээний 210,0 сая төгрөгний вакцин, тарилгыг Сонгины био үйлдвэрээс, малын бусад эмийг “Цагаан залаа”, “Вит-И-нет” аж ахуйнуудаас гэрээгээр авч урьдчилан сэргийлэх арга хэмжээг явуулсан байна.  /Хэрэгжилт-100%/
23	5.23.Газар тариалангийн салбарт техникийн шинэчлэл хийх, усалгаатай газар тариаланг өргөжүүлэх	<i>Усалгаатай нөхцөлд тариалах талбайн хэмжээ /Мянган га/</i>	Нийт 410 га усалгаатай талбайд тариалан эрхэлж байна. Сүүлийн жилүүдэд “Бор балгас”, “Бумбат”, “Хоолт”, “Эхийн гол”-ын услалтын системүүдийг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинэчлэн засварлаж ашиглаж байна.  /Хэрэгжилт-100%/
24	6.2.Хот болон аймгийн төвүүдийн гэр хорооллын дэд бүтцийг сайжруулах төслийг боловсруулж, гэр хорооллын доторхи зам, цэвэр усны шугам, гэрэлтүүлэг зэрэг дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэж эхлэх	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Аймгийн төвийн Хөх толгой чиглэлд 2 ширхэг шинэ дэд станцыг 13.3 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий барилга байгууламжийн хамт “Баянхонгор-Эрчим хүч” ХХК барьж ашиглалтад орууллаа.  /Хэрэгжилт-90%/
25	6.3.Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан орон сууцаар хангах ажлыг үргэлжлүүлэх, “Орон сууц” үндэсний хөтөлбөр	<i>Шинээр ашиглалтад орох орон сууцны тоо</i>	“Хонгор-1000” орон сууцны хөтөлбөр хэрэгжүүлэхээр ажлын хэсэг байгуулагдан газрын байршлын асуудлыг шийдвэрлээд байна.  /Хэрэгжилт-90%/

	боловсруулж хэрэгжилтийг эхлэх		
26	7.1.3.Өндөрхаан-Сүмбэр, Тэрхийн гүүр-Их-Уул, Баянхонгор-Нарийнтээл, Арвайхээр-Баянхонгор, Хануйн гүүр-Халзан бүргэдэй-Тэрхийн гүүр, Өлгий-Цагаан нуур, Дашинчилэн-Орхоны гүүр, Хөшөө цайдам-Өгий нуур чиглэлийн замуудыг үргэлжлүүлэн барих	<i>Ашиглалтад орох автозамын урт /км/</i>	Баянхонгор-Нарийн тээлийн 50 км хатуу хучилттай авто зам барих ажлын нийт төсөвт өртөг нь 10 тэрбум төгрөгөөс 2009 онд 9500,0 сая төгрөгийн барилга угсралтын ажил хийхээр санхүүжилтийн эх үүсвэр батлагдан 30 км замыг “Чайлган” ХХК, дараагийн 20 км замын ажлыг “АЗЗА” ХХК хийхээр гэрээ байгуулан ажиллаж 3.0 тэрбум төгрөгийн угсралтын ажил гүйцэтгээд байна.  /Хэрэгжилт-100%/
27	7.4.Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулах, тээврийн хэрэгслээс хүрээлэн буй орчин, хүн ам, замын хөдөлгөөнд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	-Хот хоорондын зорчигч тээвэрт 2008 онд 28 хүний суудалтай дунд оврын автобус явж байсан бол 2009 онд парк шинэчлэлт хийж 45 хүний суудалтай том оврын автобусаар иргэдэд үйлчилж эхэллээ. Одоогоор тээвэрлэгч 2 аж ахуйн нэгжийн 16 том оврын автобус өдөр бүр өглөө 08 цагаас 1 удаа, шаардлагатай үед нэмэгдлээр үйлчилж байна. -Хотын доторхи нийтийн тээврийн үйлчилгээний маршрутыг 09 дүгээр сард 3 чиглэлээр гаргаж аймгийн Засаг даргаар батлуулж “ГАЗ-ОД” ХХК нь 25 хүний суудалтай Солонгос улсын ASIA маркийн автобусыг 11 дүгээр сарын 02-ны өдрөөс 2 чиглэлд явуулж эхлээд байна. “Бодь хүч” ХХК нь суудлын 4 автомашинаар дуудлагын такси үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.  /Хэрэгжилт-100%/
28	9.1.Айл өрх бүрийг интернэтийн хэрэглэгч болгох, малчид гар утас ашиглах нөхцлийг бүрдүүлэх, шилэн кабельд холбогдсон сумдад электрон шуудангийн үйлчилгээ нэвтрүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулах	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Эрдэнэцогт, Баян-Овоо, Галуут, Богд, Жинст, Бөмбөгөр, Бууцагаан, Хүрээмарал, Өлзийт сумдад шилэн кабелийн өндөр хурдны интернетийн үйлчилгээ үзүүлж байна. Аймгийн бүх сумууд үүрэн телефоны үйлчилгээтэй боллоо. Үүнд : Өлзийт, Баянлиг, Баянговь, Баянцагаан, Баянбулаг, Жаргалант сумууд Мобиком, Жинст, Богд, Баацагаан, Эрдэнэцогт, Баян-овоо сумд скайтель, Бууцагаан, Хүрээмарал, Бөмбөгөр, Гурванбулаг Жи-

			Мобайль, Жаргалант, Заг, Гурванбулаг, Баян-Овоо сумууд Юнителийн үйлчилгээгээр тус тус хангагдсан.  /Хэрэгжилт-100%/
<b>ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧИН, БУС НУТАГ, ХӨДӨӨГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО</b>			
29	10.1.Байгалийн нөөц баялгийг тогтвортой ашиглах, хүрээлэн буй орчныг нөхөн сэргээх, хамгаалах урт хугацааны бодлого боловсруулж хэрэгжүүлэх, байгаль орчинд халгүй дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг бодлогоор дэмжих, хэрэгжилтэд хяналт тавих	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Байгаль орчны мастер төлөвлөгөөг боловсруулаад байна. Баян-Овоо сумд Швейцарийн хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр байгаль орчинд хоргүй дэвшилтэт технологээр “Хүдэр” боловсруулах үйлдвэр байгуулах ажил эхлээд байна.  /Хэрэгжилт-90%/
30	10.3.Мэргэжлийн байгууллага, олон нийтийн оролцоонд түшиглэн ой бүхий талбайг эзэмшүүлэх үндсэн дээр ойг нөхөн сэргээж, хамгаалах менежментийг бүрдүүлэх	<i>Нөхөрлөл, аж ахуйн нэгжид эзэмшүүлсэн ойн сангийн эзлэх хувь</i>	Ойн сангийн тодорхой хэсгийг нөхөрлөл, аж ахуйн нэгжид гэрээгээр эзэмшүүлснээр ойн нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, үржүүлэх, зохистой ашиглах зорилгоор ой хамгаалах нөхөрлөлийг Эрдэнэцогт сумд 11 нөхөрлөл байгуулж, Галуут сумд 3, Баянлиг сумд 3, Өлзийт сумд 1 нийт 18 нөхөрлөл байгуулан ажиллаж байна. Ойжуулалтын ажлын чанар, үр нөлөөг дээшлүүлэх үүднээс иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын тарьж ургуулсан модыг худалдан авах журмыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2009 онд Жинст сумын иргэн Баянжаргалын тарьж ургуулсан ой модыг “ таримал ойг худалдан авах журмын дагуу урамшуулал олгоод байна. Хаврын улирал эхэлж байгаатай холбогдуулан ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх талаар тодорхой ажил зохион байгуулж анхаарал болгоомжтой явах талаар иргэдэд сурталчилах ажлыг ой бүхий сумдад хэрэгжүүлэн санамж хуудас 1000 ширхэгийг хэвлүүлэн тарааж, сумдын ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөөнд хяналт тавьж ажиллаа.  /Хэрэгжилт-100%/
31	10.4.Ойжуулалт, мод үржүүлгийн ажлын чанарыг дээшлүүлэх, хууль бусаар мод бэлтгэхтэй тэмцэх, ойн түймрээс урьдчилан сэргийлэх	<i>Ойжуулалтын хэмжээ /Мян/га Тарьц,</i>	“Хууль бусаар мод тээвэрлэхгүй, огтлохгүй, худалдан авах буюу худалдан борлуулахгүй байх” талаар санамж өгч гэрээ хийлээ. Аймгийн хэмжээнд хэрэглэгдэх хэрэглээний болон түлшний модны хэмжээг гаргаж Архангай аймаг, “Баянтээх” хоршоотой гурвалсан гэрээ

	ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	суулгацны тоо /Мян/га	байгуулан ажиллаж байна. <i>/Хэрэгжилт-90%/</i>
32	10.5.Ойн цэвэрлэгээ хийх замаар түймэрт шатсан болон өмхөрч, өгөршсөн унанги модыг цэвэрлэж түлшинд хэрэглэдэг тогтолцоог бий болгох	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Эрдэнэцогт сумын Өртөмтийн урд салаанд 2007 онд ой хээрийн түймэр гарч 10 га ой шатсаныг 2009 онд мэргэжлийн байгууллагын дүнгэлт гаргаж БОАЖСайдад хүсэлт тавьсны үндсэн дээр Өртөмтийн урд салааны шатсан ойг сумын ажилгүй иргэдийг дайчлан, цэвэрлэгээг хийж сумын иргэдийн түлшинд хэрэглэж байна. Галуут сумын ЗДТГазар нутгийн иргэдийг дайчлан ой цэвэрлэх ажил зохион байгуулсан байна. <i>/Хэрэгжилт-90%/</i>
33	10.6.Голуудын сав газрын менежментийн зөвлөлийг байгуулах, зарим голын эхийг тусгай хамгаалалтад авах	Тусгай хамгаалалтад хамрагдах голын эхийн тоо	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 73 дугаар тогтоолоор Түйн гол, Байдрагийн голын ай савын зөвлөлийг шинэчлэн байгуулан ажлын төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх ажил эхлээд байна. <i>/Хэрэгжилт-70%/</i>
34	10.9.Ан амьтны тархац, нөөцийг тогтоож, хамгаалах менежментийг боловсронгуй болгох ажлын хүрээнд иргэд, аж ахуйн нэгжийн ан амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх санаачилгыг дэмжих	Идэвхитэй үйл ажиллагаа явуулах нөхөрлөлийн тоо	Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнтэй хамтран Бууцагаан, Богд сумдад нутагшуулсан тарваганы тоо толгой, өсөлтийн байдалд 9 сард мониторинг хийв. Мониторингын үр дүнд Бууцагаан суманд нутагшуулсан 13 толгой тарвага 40 орчим болж өссөнийг тогтоов. <i>/Хэрэгжилт-100%/</i>
35	11.5.Газрын нэдсэн төлөвлөгөөг УИХ-аар батлуулж, нийслэл, аймгуудын төв болон төвлөрсөн суурингийн гэр хорооллыг барилгажуулахаас бусад газруудыг зөвхөн нээлттэй дуудлага худалдаагаар худалдах тогтолцоонд шилжих	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2009 онд “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-ний дагуу 27 нэгж талбарт 3 удаа дуудлага худалдаа зарлан зохион байгуулж худалдаа үйлчилгээний 1925м <sup>2</sup> , үйлдвэр үйлчилгээний 3000м <sup>2</sup> , авто гражийн 192м <sup>2</sup> , бүгд 14 нэгж талбар бүхий 5117м <sup>2</sup> газрыг дээд үнээр нь худалдаж 18660.0 мянган төгрөгийг төсөвт орууллаа. Аймгийн Засаг даргын захирамжаар 14 иргэнтэй газар эзэмших гэрээ байгуулан гэрчилгээ олголоо. <i>/Хэрэгжилт-100%/</i>
36	11.7.Говь, хээр, цөлжилт ихээр явагдаж байгаа бүс нутгуудад усны нөөцийг нэмэгдүүлэх, мод, бут сөөг тарьж ургуулах ажлыг эрчимжүүлэх	Үйл ажиллагааны	“Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд 2009 онд улсын төсвөөр 10 га-д ойн зурвас байгуулах хөрөнгийн асуудлыг БОАЖЯам батлан өгсөн бөгөөд Бөмбөгөр сумын Хунцатад “ЖИ-СА-ОЙ” ХХК 8 га газарт хайлаас 3500 ш, бургас 200ш, улиас 800ш, чацаргана 100ш,

37	11.7.1.Говь, хээрийн бүсэд усан сан, хөв байгуулах, мод бут сөөг тарьж ургуулах ажлын үр дүнг сайжруулан арчилгаа, хамгаалалтыг сайжруулах	<i>хэрэгжилтээр</i>	нийт 4600 ширхэг мод тарьж ойн зурвас байгуулав. Мөн Богд сумын Хориултын буланд 2 га –д 450 ш чацаргана, 85 ш үхрийн нүд, 70 ш хайлаас, 30 ш улиас, мөн загийг үрээр бортгонд тарьж ургуулав. <i>/Хэрэгжилт-100%/</i>
38	11.8.Говь, хээрийн цөлжилт ихээр явагдаж байгаа бүсүүдэд баянбүрд үүсгэх, худаг ус гаргах, усжуулах бүхий л санал, санаачилгыг дэмжиж, “Ус” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх, хөдөөгийн баг бүрт сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан шинээр 1 худаг нэмж гаргах ажлыг эхлүүлэх	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	2009 онд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, аймгийн Засаг даргын хооронд бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээнд тусгагдсан 8 булаг шандын эхийг хамгаалах ажлын хүрээнд Эрдэнэцогт, Заг, Галуут, Шинэжинст, Баянхонгор, Баацагаан, Баянбулаг сумдын нутаг дахь 11-н булгийг тохижуулахаар гүйцэтгэгч нартай гэрээ байгуулан гүйцэтгээд байна. Мөн “Тогтвортой амжиргаа-II” төсөлтэй хамтран аймгийн хэмжээнд булгийн эхийг тохижуулах, бэлчээр хашиж хамгаалах, гар худаг гаргах зэрэг ажлыг 18 сумд хийж эхлээд байна. Үүнээс 15 булгийн эхийг хашиж хамгаалах, 18 бэлчээрийн газрыг хашиж хамгаалах, 12 гар худаг гаргах төслүүд хэрэгжиж эхлээд байна. Говийн 10 сумд энгийн уурхайн 47 худаг шинээр гаргаж, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 12 гүн өрмийн худаг шинээр гаргаж, 2 худаг засварласан байна. <i>/Хэрэгжилт-100%/</i>
39	11.11.Үйлдвэрлэл, үйлчилгээний менежментийг боловсронгуй болгож, хог хаягдлын хэмжээг багасгах, дахин ашиглах, томоохон хот, суурин газруудын хог хаягдлын зориулалтын төвлөрсөн цэгийг байгуулах, ландфиллийн аргыг нэвтрүүлэх	<i>Тохижуулах хог, хаягдлын төвлөрсөн цэгийн тоо</i>	Аймгийн Засаг даргын 2009 оны 14-р захирамжаар Баянхонгор сумын хогийн цэгийн байршлыг тогтоох комисс томилон Баян-Овоо сумын нутагт 5 га газрыг хогийн цэгийн зориулалтаар олгов. Шинэ хогийн цэгийг байгуулах гүйцэтгэгч нарын дунд тендер зарлан, тендерт (Чандмань-БН) ХХК шалгарч ажлыг эхлүүлэн ажлын явц 50%-ийн аргаар дарах ажлыг “Чандмань БН”ХХК хийж гүйцэтгэв. <i>/Хэрэгжилт-70%/</i>
40	11.15.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний чанар, үр дүнг нэмэгдүүлж, олон нийтийн хяналтын оролцоог өргөтгөх	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Баянхонгор аймгийн хэмжээнд иргэн Б.Содномдагвын “Зоогийн газрын барилга” –ын төсөл, “Хими цэвэрлэгээний газар” - ын төсөл, “48 айлын орон сууцны барилга” – ын төсөл, “Эмийн сангийн өргөтгөл” -ийн төсөл, иргэн Ч. Сайнбаярын худалдаа үйлчилгээний газрын барилгын төсөл, “Наран төгрөг” дэлгүүрийн барилгын төсөл, Өлзийт сумын иргэн П. Батбаярын 2 дэлгүүрийн барилгын төсөл, мөн сумын ЗДТГ-ын барилга, нам даралтын зуух, Баянхонгор аймгийн тээрийн үйлчилгээний төвийн барилгын төсөл, Баянлиг сумын иргэн Ц.

			Бийбатын 1 га бэлчээр хаших “Нутгийн шим” төсөл зэрэг 91 төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгээд байна. /Хэрэгжилт-100%/
41	11.18.Цаг агаарт зориудаар нөлөөлөх замаар хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг оновчтой зохион байгуулах	<i>Хөдөлгөөнт багийн тоо Газрын генератор</i>	2009 оны 04 сарын 13-ны өдрөөс 04 сарын 23-ны өдрүүдэд УЦУОШГазрын “Хурын шим” төвийн мэргэжилтнүүдийн зохион байгуулсан сургалтад УЦУОШАлбаны холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан цаг агаарт зориудаар нөлөөлөх экспедиц ажиллуулах эрх олгуулж цаг агаарт зориудаар нөлөөлөх хээрийн экспедицийг 3 удаа зохион байгуулж ажиллан хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагаа явууллаа. 2009 оны 05 сарын 05-08-нд ажиллаж хээрийн экспедиц нутгийн баруун өмнө хэсгээр орж ирсэн үүлний массад нөлөөллөө. Нийт тунадасны хэмжээ – 164.8 мм. 05 сарын 27-28-ний хооронд аймгийн нутаг дэвсгэрийн 90 хувьд 0.0-20.0 мм хүртэл тунадас орсон. Нийт орсон тунадасны хэмжээ 148.3 мм. Баянхонгор аймгийн зуншлагын байдлыг авч үзэхэд 2009 оны 8-р сарын байдлаар 10.2 хувь нь зуншлагтай 75 хувь нь гандуу, 14.8 хувь нь гантай байна. 2010 онд 25 сая төгрөгөөр газрын генераторыг улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэж Түйн голын эхэнд байрлуулахаар болоод байна. /Хэрэгжилт-100%/
<b>ДӨРӨВ. ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БОДЛОГО</b>			
42	13.1.Хүн амын өсөлтийг дэмжих хүрээнд хүүхдийн мөнгө, шинэ гэр бүл, шинэ хүүхэд хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	0-18 насны 34174 хүүхдэд хүүхдийн мөнгө, 468 шинэ гэр бүлд шинэ гэр бүлийн тэтгэмж, 1368 төрсөн хүүхдэд хүүхдийн мөнгийг тус тус олгосон. /Хэрэгжилт-100%/
43	13.4.Ядуурлыг тодорхойлох аргачлалыг шинэчлэн боловсруулж, ядуурлын зураглал гаргах бэлтгэлийг ханган мэдээллийн сангийн нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	2009 онд 470 өрхийн мэдээллийн санг бүрдүүлсэн. 2010 онд 450 өрхийг ядуурлаас гаргах, мэдээллийн санг бүрдүүлэх ажил эхлээд явж байна. /Хэрэгжилт-100%/
44	13.5.Ажлын байр шинээр бий болгох замаар хүн амын ажил	<i>Ажил эрхлэлтийн</i>	2009 оны байдлаар 1999 хүнийг ажлын байранд зуучилснаас 1224 хүн байнгын зохистой ажлын байранд, 775 хүн түр ажлын байраар

	эрхлэлтийн түвшинг нэмэгдүүлэх	<i>түвшин /Хувиар/ Ажлын байр шинээр бий болгох</i>	хангагдсан байна. ХААН, Монгол Шуудан, Капмон банк бус санхүүгийн байгууллагаар дамжуулан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн жижиг зээлийн сангаас 173,7 сая төгрөгийн зээлийг түлш, хүнс, барааны жижиглэн худалдаа, малтай болох зэрэг чиглэлээр олгож 253 ажлын байр, 53,4 сая төгрөгийн зээлийг мал амьтан, үр бордоо, тоног төхөөрөмж худалдан авч ажил үйлчилгээгээ өргөжүүлэхэд олгож 99 ажлын байр, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төслийн хүрээнд 52 төсөлд 815.0 сая төгрөг олгож, 519 ажлын байр нийт 871 ажлын байр шинээр бий болсон.  /Хэрэгжилт-100%/
45	13.13.Өрхийн аж ахуйг дэмжин жижиг зээлийн үйлчилгээг өргөжүүлж, хөдөө орон нутаг, сумдад хүргэх	<i>Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн эх үүсвэр /Сая.төгрөг/</i>	Аймгийн Засаг даргын 2009 оны 214-р захирамжаар жижиг дунд үйлдвэр хөгжүүлэх чиглэлээр ирүүлсэн төслүүдэд хөнгөлөттэй зээл олгох ажлыг хэлэлцэн зохион байгуулах ажлын хэсгийг 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллаж ажлын хэсэг нийтдээ 11 удаа хуралдаж нийт ирүүлсэн 1,4 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 76 төслийг хугацаанд нь хэлэлцэн 815,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 52 төслийг шалгаруулан банкинд хүргүүлсэн.  /Хэрэгжилт-100%/
46	13.14.Иргэдийн нэрийн дансны мөнгийг баталгаажуулж, тэдний нийгмийн даатгалд итгэх итгэлийг нэмэгдүүлж, мэдээллийг ил тод болгох арга хэмжээг хэрэгжүүлэх	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Нийт 13600 хүний нэрийн дансийг нээн ажиллаж байгаагаас 2009 онд шинээр 215 хүн хамруулаад байна.  /Хэрэгжилт-100%/
47	13.15.Малчин бүрийг нийгмийн болон эрүүл мэндийн даатгалтай болгох ажлыг эхлүүлэх	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Сайн дурын даатгалуулагч 1190 иргэд, малчдыг эрүүл мэндийн даатгалд хамруулж 119.9 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна .  /Хэрэгжилт-90%/
48	13.16.Нийгмийн хамгааллын бүртгэлийн тогтолцоог бий болгох	<i>Нийгмийн хамгааллын дугаарын сүлжээ бүрдэнэ</i>	Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтэс дээр эмзэг бүлгийн мэдээллийн санг бий болгон ажиллаж байна.  /Хэрэгжилт-100%/
	14.1.Сургуулийн өмнөх	<i>Сургуулийн</i>	2009-2010 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын 146

49	боловсролын сургалтын агуулга, хөтөлбөрийг сайжруулах	<i>өмнөх боловсролын хамран сургалт /Хувь/</i>	бүлэгт өдрөөр 2665, хувилбарт сургалтад 1847 хүүхэд нийт 4665 хүүхэд хамрагдаж хамран сургалт 77,7 хувьтай байна. <i>/Хэрэгжилт-100%/</i>
50	14.2.Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн “Үдийн цай” хөтөлбөрийг үргэлжлүүлэх	<i>Хамрагдах анги</i>	2009-2010 оны хичээлийн жилд 1-5-р ангийн 324 бүлгийн 9647 хүүхэд “Үдийн цай” хөтөлбөрт хамрагдаж байна. <i>/Хэрэгжилт-100%/</i>
51	14.3.Ерөнхий боловсролын сургалтыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэх	<i>6 настай хүүхдийн хамран сургалт /Хувь/</i>	2009-2010 оны хичээлийн жилд шинээр 1-р ангид 6 настай 1242 хүүхэд элсэн орсон нь нийт 6 настай хүүхдийн 99 хувь нь хамрагдсан байна. <i>/Хэрэгжилт-100%/</i>
52	14.5.Ерөнхий боловсролын сургуулийн 3 ээлжээр хичээллэдэг байдлыг багасгаж, сурагчдын дотуур байрны хүрэлцээг нэмэгдүүлэх	<i>Шинээр нэмэгдэх суудлын тоо</i>	Аймгийн төвд 640 хүүхдийн суудалтай хичээлийн шинэ барилга ашиглалтад орсноор бүх сургууль 2 ээлжээр хичээллэж байна. <i>/Хэрэгжилт-100%/</i>
53	14.6.Хөдөөгийн сургуулийн дотуур байрны хангамжийг нэмэгдүүлэх	<i>Шинээр нэмэгдэх дотуур байрны орны тоо</i>	Дотуур байранд амьдрах хүсэлт гаргасан 2252 хүүхдийн 2201 нь хамрагдаж 98 хувьтай байна. <i>/Хэрэгжилт-100%/</i>
54	14.7.“Хүүхэд бүрт компьютер” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	<i>Хөтөлбөрт хамрагдах хүүхдийн тоо /Мянга/</i>	2009-2010 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын 31 сургуульд 18144 хүүхэд суралцаж байна. Сургалтад 414 компьютер ашиглагдаж байна. <i>/Хэрэгжилт-100%/</i>
55	14.8.Ерөнхий боловсролын сургуулийг интернэтэд холбох ажлыг эрчимжүүлэх	<i>Цахилгааны байнгын эх үүсвэртэй сумдын тоогоор</i>	Аймгийн төвийн 6 сургууль интернетэд холбогдож сургалтад ашиглаж байна. Хүрээмарал Баянбулаг, Баянцагаан, Баян-Өндөр, Шинэжинст сумдаас бусад сум төвлөрсөн цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй тул цаашид интернетэд холбогдох бүрэн боломжтой болсон. <i>/Хэрэгжилт-70%/</i>
	14.9.Ерөнхий боловсролын	<i>Үйл</i>	Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтын хөтөлбөр, агуулгыг

56	сургуулийн ахлах ангийн сурагчдад мэргэжлийн баримжаа олгох сургалтын хөтөлбөр, агуулгыг боловсронгуй болгох	<i>ажиллагааны хэрэгжилтээр</i>	боловсронгуй болгож Номундалай, Номгон, Баянцагаан, Соого Сейкео сургуулийн 43 бүлгийн 689 хүүхдийг хамруулж байна. <i>/Хэрэгжилт-100%/</i>
57	14.10.Англи хэлний үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Англи хэлний анхан шатны сургалтын хөтөлбөрийг боловсруулж 80-90 цагийн сургалтыг Аймгийн Засаг Даргын Тамгын Газрын ажилтнууд, Цагдаагийн Хэлтэс, Татварын Хэлтэс, Нийгмийн Даатгалын Хэлтэс, Мэдээлэл Харилцаа Холбоо Сүлжээний Компани, Хөдөлмөр Халамж Үйлчилгээний хэлтсийн ажилтнуудад Номгон, Эрдэнэмандал, Номундалай сургуулиудын англи хэлний багш нартай хамтран Төрийн албан хаагчдын дунд зарласан “Англи хэл сурцгаая” аяны хүрээнд явууллаа. Аймгийн төвөөс 200 ажилтан албан хаагчид Баянлиг, Бууцагаан, Баянцагаан, Гурванбулаг сумдад 301 хүн хамрагдсан байна. “Англи хэлний сургалтыг эрчимжүүлэх нь”вакуумжуулсан сургалтад аймгийн төв, хөдөө сумдын 28 багшийг хамруулж мөн тус хөтөлбөрийн хүрээнд сургуулиудад “Lesson planner”ном 59 ширхэгийг, Flash cards, Oxford English Dictionary 118 ширхэгийг, нийт 177 ширхэг номыг сургалтын хэрэглэгдхүүн болгон тараалаа. <i>/Хэрэгжилт-90%/</i>
58	14.27.Үндэсний уламжлалт соёлын өвөө хадгалж хамгаалах, сэргээн засварлах, хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Үндэсний түүх, нүүдлийн соёлоо судлан сурталчлах, монгол бичгээ өвлүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж “Монгол бичиг”, “Морин хуур”, уртын дуу, монгол хөөмий, монгол бий, биелгээ, түүх соёлын үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Ламын гэгээн Лувсанданзанжанцантай холбоотой үзмэрүүдээр ил захидал хэвлүүлж ард иргэдэд сурталчилж байгаагийн зэрэгцээ, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2009 оны 136 дугаар тогтоолоор Галуут сумын нутаг дахь “Хонгор хайрхан” уулыг “Аймгийн тахилгат” уул болгож, музейн лого болох МЭӨ 3-4- р зууны холбогдолтой хос хүрэл морины хөшөөг 9.0 сая төгрөгөөр бариулсан. Аймгийн Музейн бүртгэл мэдээллийн санд байгаа ТСД-газруудын видео цомог хийж эхлээд байна. Сумдын соёлын төвүүд нутаг дэвсгэртээ байгаа ТСҮХДГ-ын фото альбомыг цахим хэлбэрээр хийж ЕБС-ийн сурагчдийн хичээлд хэрэглэж сурталчилж байна. “Морин хуур-уртын дуу” үндэсний хөтөлбөрийн

			<p>хүрээнд морин хуурч, уртын дууч, морин хуур урлаачдын нэгдсэн судалгаатай болж тэдний арга барил, дэг сургуулийг өвлүүлэн, алдаршуулах, сургалт сурталчилгаа, төрөл бүрийн уралдаан наадмуудыг жил бүрийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж жилдээ 2.4 сая төгрөгийг “Морин хуур, уртын дуу” хөтөлбөрийн хэрэгжилтэд зарцуулан хөтөлбөр 93.3 хувьтай хэрэгжиж байна. Монгол хөөмий, Монгол уламжлалт бий, биелгээ хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2009 оны 91-р захирамжаар батлан уг хөтөлбөрүүдийг Утга соёлын өвийн үндэсний төвтэй хамтран үүсэл хөгжил, тархалтыг судлан холбогдох байгууллага, ажилтнуудын дунд сургалт зохион байгуулж, сургалтын CD- авч сургагч багш бэлтгэж байна. Хөөмий сонирхогч залуучуудын дунд хөөмийн сургалтыг ХДТ, Соёлын төвүүдийг түшиглэн бүсчлэн зохион байгуулж одоогоор 20 гаруй хөөмий сонирхогч залуучууд суралцаж, амжилттай суралцсан Баян-өндөр сумын ардын авъяастан н.Мөнхбаярыг СУИС-ийн хөөмийн ангид суралцуулахаар сургалтын албатай тохиролцоод байна.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-100%/</p>
59	14.28.Сумын соёлын төвийн үйл ажиллагааны агуулга, хэлбэрийг баяжуулж тогмолжуулах, соёлын төвүүдийн барилгыг шинэчилж засварлах, хөгжмийн зэмсэг, ном, тоног төхөөрөмжөөр хангах замаар хүүхэд, залуучууд, хүн амд хүргэх соёлын үйлчилгээний нийгмийн үр өгөөжийг дээшлүүлэх	<p><i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i></p>	<p>2009 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянбулаг сумын соёлын төвийн барилгын дуусгалыг 24.5 сая төгрөгөөр, Баян-өндөр сумын соёлын төвийн барилгын дуусгалд 30.1 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж барилгын ажил 80%-тай явагдаж байгаа ба Баянцагаан, Бууцагаан сумын соёлын төвийн барилгын зураг төсвийг хийж БСШУЯ-нд хүргүүллээ.</p> <p>Өрхийн амьжиргаа төслөөр Баянлиг сумын соёлын төв 10 сая төгрөгийн тохижилт, Баацагаан сумын соёлын төв 10 сая төгрөгийн халаалт, засвар, Галуут сумын соёлын төв 5 сая төгрөгийн халаалт, цонх, Бууцагаан сумын соёлын төвийн засвар тохижилт 3.3 сая, ДЗОУБ-ийн санхүүжилтээр 8.0 сая төгрөгийн засвар тохижилт, Гурванбулаг сумын номын сангийн засвар, тохижилтод 11.5 сая төгрөгийн ажлууд хийгдэж нийт 2009 онд улсын төсөв, тогтвортой амьжиргаа, ДЗОУБ-ын хөрөнгө оруулалтаар нийт 102.4 сая төгрөгийн засвар, халаалт, тохижилтын ажлууд тус тус хийгдлээ.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт-100%/</p>
	15.1.4.Аймаг бүрт 5-6 сумын дунд		2009 онд аймгийн нэгдсэн эмнэлэгт явуулын амбулаторийн

60	явуулын амбулаторийн үйлчилгээг байгуулж, тоноглогдсон тээврийн хэрэгслээр хангах ажлыг судлах, бэлтгэл ажлыг хангах	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	үйлчилгээний тоног төхөөрөмжөөр тоноглогдсон 2 автомашинтай болж, сумдын иргэдэд үйлчилж байна.  /Хэрэгжилт-50%/
61	15.2.1.Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудыг нэгдсэн сүлжээнд холбох, мэдээлэл, технологийн мэргэжилтэн бэлтгэж хангах ажиллагааг судлан, хөрөнгө, санхүүгийн тооцоо хийх	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Эрүүл мэндийн салбарын хүрээнд 2 байгууллага, Хүрээмарал, Бууцагаан сум интернетэд холбогдож, 150 гаруй ажилтан компьютер эзэмшиж, салбарын вэб сайтыг аймгийн нэгдсэн сүлжээнд оруулж, хүн амын эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн санд байршуулснаар хүн амын эрүүл мэндийн талаарх мэдээллийг олон нийтэд түгээх боломжтой болсон.  /Хэрэгжилт- 70%/
62	15.6.Малчин, ядуу, эмзэг бүлгийн хүн амыг нөхөн үржихүйн эм, хэрэгслээр тогтвортой хангах ажлыг үе шаттайгаар эхлүүлэх	<i>Нэн шаардлагатай эмийн хангалт /Хувь/</i>	“Нөхөн үржихүйн эрүүл мэнд-III” хөтөлбөрийн хүрээнд нөхөн үржихүйн эм хэрэгслээр 100 хувь хангагдаж, гэр бүл төлөвлөлтөд ашиглаж байна.  /Хэрэгжилт-100%/
63	15.9.Халдварт өвчний халдварыг хязгаарлах, урьдчилан сэргийлэх, тархалтыг бууруулах арга хэмжээг өргөжүүлж, өвчин эсэргүүцэх тарилга, вакцин, эм хангалтыг нэмэгдүүлэх	<i>Халдварт өвчнийг бууруулах хувь Тарилга вакцины нөөцлөлтийн хувь</i>	ЭМЯ, ХӨСҮТ-тэй хамтарч нэгдсэн эмнэлэг, өрхийн эмч нарт эмнэлзүйн болон лабораторийн оношлогооны сургалтыг хийсэн. 11 сард /H1N1/шинэ вирусын халдварын сэжигтэй тохиолдлуудад лабораторийн шинжилгээ хийлгэж 4 тохиолдол баталгаажсан. ЭМЯ-аас хуваарилагдан ирсэн хувийн хамгаалах хэрэгсэл, амны хаалт, эм ариутгал, халдваргүйтгэлийн бодис, эм, хэрэгслийг хуваарийн дагуу нэгдсэн эмнэлэг, сум, өрхийн эмнэлэгт олгосон. ЭМЯ-аас хуваарилсан амьсгалын аппарат 1, компьютер, техник хэрэгслийг нэгдсэн эмнэлгийн халдвартын тасагт байршуулан үйл ажиллагаа явуулж байна.  /Хэрэгжилт-100%/
64	15.13.Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор бүсийн болон аймаг, нийслэлд шүдний кабинет байгуулах ажлыг дэмжиж,	<i>Байгуулах шүдний кабинетийн тоо</i>	Нэгдсэн эмнэлгийн амбулатори нь шүдний 3 кабинет ажиллуулж, “Эрүүл шүд сайхан инээмсэглэл” аян зохион байгуулж говийн бүсийн 10 сумын сургуулийн 7724 сурагчдад шүдний өвчнийг илрүүлж, эрүүлжүүлснээр хүүхдийн шүдний өвчлөл 52 хувиар буурлаа.  /Хэрэгжилт-100%/

	хэрэгжүүлэх		
65	15.14.Сум, өрхийн эмчийг бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх тогтолцоо болон орон нутагт ажиллах эмч нарын урамшууллыг боловсронгуй болгох замаар анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмчийн хангалтыг сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2009 оны 222 дугаар тогтоолоор аймгийн эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх” 15 жилийн хөтөлбөр батлуулан хэрэгжүүлж эхлээд байна.  /Хэрэгжилт-90%/
66	15.17.Нийтийн биеийн тамир, спортын материаллаг баазыг өргөтгөхөд дэмжлэг үзүүлэх, нийтийн биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогыг батлуулж, хэрэгжүүлж эхлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	УИХ-ын тогтоолоор батлагдсан “Биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлого”-ыг аймаг орон нутагт хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Биеийн Тамир спортын Газрын гадна талбайд 100,0 /Нэг зуун сая/ төгрөгийн хөрөнгө оруулалтаар хөл бөмбөгийн орчин үеийн стандартын ногоон талбайг хийж ашиглалтад авсан. -МСҮТөвийн гадна талбайд нийтийн биеийн тамирын стандартын талбай, жижиг цэнгэлдэх хүрээлэн, Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний “Бат-Ндэр” ХХКомпанитай хамтарч ажилчдын сагсан бөмбөгийн гадна талбай, Эрдэнэмандал ахлах сургуулийн гадна талбай, ОБХэлтсийн дэргэд сагсан бөмбөг, гар бөмбөгийн задгай талбайг шинээр барьж байгуулсан. - Гэр хорооллыг олон нийтийн санаачлагаар хөгжүүлэх төслийн хүрээнд Баянхонгор сумын 5 дугаар багийн иргэдтэй хамтарч спорт тоглоомын гадна талбайг 6 дугаар гудамжинд байгуулахаар зураг төсвийн дагуу хийсэн. - Аймгийн ИТХ-тай хамтран боксын “Бүргэд Баянхонгор” клубүүд шинээр тоног төхөөрөмж авчирч нээн ажиллуулж байна. Биеийн тамир спортын газрын дэргэд Бодибилдинг чийрэгжүүлэлтийн Стронг клубыг ажиллуулж нийтийн биеийн тамир чийрэгжүүлэлтийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаж байна.  /Хэрэгжилт-90%/
<b>ТАВ. ГАДААД БОДЛОГО, БАТЛАН ХАМГААЛАХ</b>			
	17.2.Хөрш 2 оронтой харилцан ашигтай, найрсаг, тэнцвэртэй		Оросын холбооны улсын Кабанскийн район, БНХАУ-ын ӨМӨЗОрны Альша аймгийн Эзний хошуунд аймгаас төлөөлөгчид айлчлав.

67	харилцааг бүхий л түвшинд хөгжүүлж, АНУ, Япон, Канад, Герман болон Европын холбооны бусад орнуудтай иж бүрэн түншлэлийн түвшинд харилцах бодлого баримтлах, Энэтхэг, БНСУ, Турк, Австрали, АСЕАН-ы орнуудтай түншлэлийн болон худалдаа, эдийн засаг, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаагаа үргэлжлүүлэн хөгжүүлэх	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	Айлчлалын үр дүнд хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурж аймагт хамтарсан үйлдвэр байгуулахаар тохиролцсон. - Австри улсад суугаа монголын төлөөлөгчидтэй холбоо барьж аймагт хог боловсруулах үйлдвэр барих саналаа дамжуулаад байна. <i>/Хэрэгжилт-30%/</i>
68	18.2.Дайчилгааны тухай хуулийн дагуу дайчилгааны бэлтгэл нөөцийн 1. 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтний, төрийн болон орон нутгийн удирдах бүрэлдэхүүний цэрэг-стратегийн, цэргийн бэлтгэл сургалтуудыг зохион байгуулах	<i>Үйл ажиллагааны хэрэгжилтээр</i>	-Сумдын Засаг даргын Тамгын дарга нартай 2009 оны 1 дүгээр сард “ Цэргийн шинэчилсэн тоо бүртгэл “ сэдвээр 1 өдрийн мэргэжил арга зүйн сургалт явуулсан. - Баянхонгор аймгийн Засаг дарга болон төсвийн ерөнхийлөн захирагч Батлан хамгаалахын сайд нарын хооронд бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн талаар байгуулсан гэрээний заалтыг хэрэгжүүлэн 20 бэлтгэл офицертой 2009 оны 3 дугаар сарын 23 – наас 4 дүгээр сарын 03 – ны өдрүүдэд “ <b>Жижиг салбаруудын байлдааны ажиллагаа</b> “ сэдэвт бэлтгэл офицеруудын давтан сургалтыг зохион явуулсан. - 2009 оны 3 дугаар сард явагдсан “ Галуут сумыг мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх ажлын чиглэлээр жишиг сум болгохтой холбогдсон сургалт, зөвлөгөөн “ – д бэлтгэл офицерууд, Галуут сумын багийн дарга, байгууллагын дарга нартай “ Батлан хамгаалах хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэхэд багийн Засаг дарга, байгууллагын дарга эрхлэгч нарын үүрэг “ сэдвээр 2 цагийн сургалт, <b>нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнүүдтэй цэргийн мэргэжил олгох сургалтыг танкын наводчик, артиллерийн хол хэмжигч, артиллерийн тагнуулчин мэргэжлээр цэргийн мэргэжил олгох сургалт зохион байгуулан явуулаа.</b> Цэргийн бэлтгэл үүрэгтэн болон бэлтгэл офицер, гэрээт цэргийн алба хаагчдад зориулан цэргийн штабын дарга Д.Жаргалсайхан, С.Баясгалан нар гарын авлага бэлтгэсэн.

			/Хэрэгжилт-100%/
69	18.5.Экологийн сүйрлээс сэрэмжлэн хамгаалах, ойжуулах, цөлжилттэй тэмцэх, байгалийг нөхөн сэргээх зэрэг ажил, үүрэг биелүүлэхэд цэргийн дүйцүүлэх албаны оролцоог нэмэгдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2010 онд хөв байгуулах, Нартын Хясаа, Гялгарын хавцгайтын замыг засварлахаар төлөвлөсөн.  /Хэрэгжилт-30%/
70	19.4.Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааг ил тод, нээлттэй болгож, цахим сүлжээнд суурилсан нэг цэгийн үйлчилгээг бий болгох	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	“Нээлттэй хяналт, эрүүл Баянхонгор” төслийг 2009 оны 01 сарын 01-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна. “Нээлттэй хяналт, Эрүүл Баянхонгор төсөл”-ийн хүрээнд нийтдээ “Баянхонгор” телевиз, “Өнөөгийн Баянхонгор” сонины 13 дугаарт 17 мэдээ сурвалжлагыг нийтлүүлж, “Хонгор”, “Баянхонгор” телевизээр 11 удаагийн тусгай сурвалжлага бэлтгэж нэвтрүүлсэн.  /Хэрэгжилт-90%/
71	19.6.Мэргэжлийн хяналтын байгууллагын лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлж, баталгаажилтын түвшинг дээшлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	2007-2008 онд шинээр спектрофотометр, рН-метр, аналитик жин, сахарын рефректометр, Eliza-уншигч, нимгэн үет хроматограф, центрифуг, сэгсрэгч, чийг хэмжигч, ламинар бокс, Зейтцийн аппарат, дижитал микроскоп, анаэрометр зэрэг хэмжих хэрэгсэл, тоног төхөөрөмжийг авч шинжилгээнд хэрэглэж байна.  /Хэрэгжилт-100%/
72	20.2.Улс оронд гарч болзошгүй гамшгийн төрлүүдэд зохицон ажиллах боломж бүхий радио холбооны зангилгаа, тухайн гамшгийн голомтоос удирдлагад шуурхай мэдээлэл дамжуулах радио сувгийг байгуулах	Холбооны радио сүлжээтэй болох	Онцгой байдлын хэлтэст мэдээлэл хүлээн авах станц суурилуулж, автомат дохиолол бүхий газруудтай шууд холбогддог станц байрлуулсан.  /Хэрэгжилт-100%/
73	20.3.Онцгой байдлын албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангах, гамшигтай тэмцэх чадавхийг дээшлүүлж, техник, зэвсэглэмжийн хангалтыг сайжруулах, томоохон хот, суурин газар, аврах шуурхай	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Онцгой байдлын хэлтсийн гал унтраах болон аврах ажлын тоног зэвсэглэмжийг өөрсдийн нөөц боломжид тулгуурлан засварлаж галын 2 машинд ээлжийн засвар, усны машинд насос тавьсан.  /Хэрэгжилт-90%/

	бүлэг 105-ыг байгуулах		
74	20.4.Гамшгаас өөрийгөө болон бусдыг хамгаалах боловсролыг иргэдэд олгох сургалтын тогтолцоог сайжруулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Аймгийн 20 сум, мэргэжлийн 7 алба, 4 тусгай зориулалтын мэргэжлийн ангийн Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг татан авч хянан баталгаажуулж, ХХААЖДҮГазар, Баянцагаан сумын Гамшгаас хамгаалах төлөвлөгөөнд тодотгол хийж, сургууль дадлагаар баталгаажуулж, Баянговь сумд гамшгаас хамгаалах иж бүрэн сургалтыг 12 сард зохион байгуулсан.  /Хэрэгжилт-100%/
75	20.6.Орон нутгийн онцлог, тохиолдож болзошгүй гамшгийн нөхцөл байдал зэрэгтэй уялдуулан улсын нөөцийн байршлыг өөрчлөх, нэмэгдүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Бууцагаан сумд улсын нөөцийн салбар байгуулах саналыг боловсруулан холбогдох байгууллагуудад санал хүргүүлсэн бөгөөд албан ёсоор хариу ирээгүй байна.  /Хэрэгжилт-30%/
<b>ЗУРГАА. ЗАСАГЛАЛ, ЭРХ ЗҮЙН ШИНЭЧЛЭЛ</b>			
76	21.5.Иргэний, эд хөрөнгийн, хуулийн этгээдийн эрх зүйн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж ашиглах, бүртгэл, мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд онлайнаар мэдүүлэг авч, хариуг онлайнаар болон шуудангаар илгээдэг журамд шилжих ажлын бэлтгэлийг хангах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан аймгийн Засаг даргаас гарч байгаа иргэнд газар өмчлүүлэх эрх үүсгэхтэй холбогдуулан гарсан 2003-2008 оны нийт 77 захирамж, 2009 оны нийт 24 захирамжийн хавсралтад дурьдагдсан өмчлөх эрх үүсч байгаа иргэнтэй холбоотой өгөдлүүдийг агуулга, төрлөөр нь ангилан мэдээллийн бичгэн болон цахим санг үүсгэн хөтлөж байна.  /Хэрэгжилт-100%/
77	21.6.Нийгмийн зохион байгуулалт, эмх цэгц, сахилга, дэг журмыг сайжруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, иргэдийн амь нас, аюулгүй байдлыг хангаж ажиллах, эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын цар хүрээ, чанар, үр нөлөөг дээшлүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хууль зүйн хэлтэс нь 2009 онд аймгийн хэмжээнд зохион байгуулах эрх зүйн сургалт, сурталчилгааны нэгдсэн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 6 удаа 506 хүнд сургалт хийж, 22 сум, байгууллагад 18 удаа захиалгат сургалт хийж 583 хүн тус тус хамрагдав. Нийт 46 төрлийн сэдвээр 29 удаа 10053 ширхэг хялбаршуулсан гарын авлага бэлтгэж түгээлээ.  /Хэрэгжилт-100%/

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН:

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН  
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАСАГ**